ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA
REPRESENTATIVE GOVERNING BOARD RESOLUTION

2026 оны 10 сарын 08 өдөр Дугаар 73 Улаанбаатар хот

"Худалдаа, хөгжлийн банкны Ёс зүйн дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 76.1.18 дахь заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.7 дахь хэсэг, "Худалдаа, хөгжлийн банк" ХК (цаашид "Банк" гэх)-ийн дүрмийн 8 дугаар 8.11.21 дэх заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. "Худалдаа, хөгжлийн банкны Ёс зүйн дүрэм"-ийн дараах дурдсан хэсэг, заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

1/ 4 дүгээр зүйлийн 4.8.1 дэх заалт:

"4.8.1. "Худалдаа, хөгжлийн банкнаас бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахад баримтлах бодлого", "TDB соёлын стандарт" болон "ХХБ-ны Харилцагчид үйлчлэх үйлчилгээний журам"-ыг дагаж мөрдөнө."

2/ 7 дугаар зүйлийг 7.3 дахь хэсэг:

"7.3. Банкны ТУЗ-ын гишүүдээс бусад ажилтан Ёс зүйн дүрмийн Хавсралт 1-т заасан "Ёс зүйн батламж"-тай, ТУЗ-ийн гишүүд Ёс зүйн дүрмийн Хавсралт 2-т заасан "Ёс зүйн батламж"-тай тус тус бүрэн танилцаж, хүлээн зөвшөөрсний үндсэн дээр Банктай байгуулсан Хөдөлмөрийн гэрээ болон ажлын байрны тодорхойлолт, хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд ажил, үүргээ гүйцэтгэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, Худалдаа, хөгжлийн банкны дүрэм, заавар, журам, "Ёс зүйн дүрэм", "TDB соёлын стандарт" болон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллахаа батламжилж гарын үсэг зурна."

2. "Худалдаа, хөгжлийн банкны Ёс зүйн дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.5.6 дахь заалтын "Худалдаа, хөгжлийн банкны бэлгийн хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах бодлого" гэснийг ""ХХБ-ны ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам" болон "Худалдаа, хөгжлийн банкны шүгэл үлээх бодлого"" гэж өөрчилсүгэй.

3. Энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу "Худалдаа, хөгжлийн банкны Ёс зүйн дүрэм"-д Хавсралт 2-ыг нэмсүгэй.

4. Энэхүү тогтоолыг 2026 оны 10 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд, Төлөөлөн удирдах зөвлөлийн харьяа газар, хэлтэс, албадын ажилтнуудад мөрдүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Н.Нямсүрэн)-д, Банкны Гүйцэтгэх удирдлагаас эхлэн үндсэн, дагалдан болон туршилтын хугацаагаар ажиллаж буй ажилтнууд, гэрээ, итгэмжлэлийн үндсэн дээр Банкийг төлөөлөх, зөвлөх зэргээр тус Банкийг төлөөлж буй бүх ажилтнуудад мөрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА **РАНДОЛФ КОППА**

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК
9023004006 4641033
TRADE AND DEVELOPMENT BANK JSC